БАТЛАВ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ж.ГАНБАТ

# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | | Хүрэх түвшин | Хэрэгжүүлэх нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хугацаа | | |
| | **1."Авлигын эсрэг үндэсний чуулган"-аас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх** | | | | | |
| | *Төрийн албаны шударга, ил тод байдлыг бэхжүүлэх чиглэлээр* | | | | | |
| 1 | Зөвлөмж 2.1. Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ, авлигын эрсдэлийн үнэлгээ зэрэг судалгааны үр дүнд тулгуурлан авлигын эрсдэл бүхий салбар, байгууллагад чиглэсэн арга хэмжээг тусгайлан авч хэрэгжүүлэх, авлигын гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах; | 7.1. Авлигын гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах | Соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх | Жилдээ | Авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | ТЗУГ, СХЭУГ |
| 2 | Зөвлөмж 2.2. Төрийн албаны их өгөгдөлд суурилсан хүний нөөцийн нэгдсэн удирдлагын цахим системийг хөгжүүлэх, ашиглалтыг нэмэгдүүлэх, ялангуяа уг өгөгдөлд суурилан төрийн албан хаагчийн томилгоог хийх. Энэхүү системийг төрийн байгууллагуудын цахим системтэй интеграцжуулахад холбогдох байгууллагууд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах; | 8.1. Төрийн албаны зөвлөлийн их өгөгдлийн санд яамны хүний нөөцийн бүртгэлийг бүрэн оруулах, хүний нөөцийн нэгдсэн удирдлагын цахим системд суурилсан тусгай шалгалтууд зохион байгуулж, албан хаагчийг томилох, бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллах | Их өгөгдлийн сангийн дагуу мэдээллийг оруулсан байх | Жилдээ | Тусгай шалгалтыг хүний нөөцийн нэгдсэн удирдлагын цахим системээр зохион байгуулж, албан хаагчийн мэдээллийг оруулсан байна. | ТАСЗ, ТЗУГ |
| 3 | Зөвлөмж 2.3. Төрийн албаны хүний нөөцийн аудитыг Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл хамтран хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн хандлага, соёлыг сайжруулах, ёс зүй, сахилга хариуцлагад тавих хяналтыг чангатгах, төрийн албаны шалгалт, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэхэд хиймэл оюун ухааныг ашиглах боломжийг судлах, ёс зүй, зан үйлийг үнэлэх сэтгэл зүй туршилтыг өргөжүүлэх; | 9.1. Төрийн албаны хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримлах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах | Авлигын эсрэг хууль, тогтоомж, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д нийцсэн байх | Жилдээ | Сургалт хөгжлийн дэд хөтөлбөр төлөвлөгөөнд тусганы дагуу хэрэгжүүлсэн байна. | ТЗУГ, Ёс зүйн зөвлөл |
| | | 9.2. Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, түүнийг үнэлэх аргачлалыг цахимжуулж ЛМЗ програмын хэрэглээг сайжруулах | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг цахим програмын тусламжтай үнэлж хэвших | Жилдээ | Албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг яамны дэргэдэх ТАСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн байна. | СХЭУГ, ТЗУГ |
| 4 | Зөвлөмж 2.4. Төрийн албаны хууль тогтоомжоор албан тушаалд тавьсан шаардлагыг хангаагүй, сонгон шалгаруулалтгүйгээр томилсон хүмүүсийг төрийн албанаас чөлөөлөх, томилсон этгээдэд хариуцлага тооцох, албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхэд онцгойлон анхаарах; | 10.1. Албан тушаалын шаардлага хангаагүй албан хаагчийг томилохгүй байх, албан үүргийг түр орлон гүйцэтгэхээр томилсон албан тушаалд тусгай шалгалт зарлан томилох | Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байх | Эхний хагас жилд, жилдээ | ТАЗ-ийн тусгай шалгалт кохион байгуулах журмыг баримтлан сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна. | ТАСЗ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | Зөвлөмж 2.5. Төрийн албан дахь статистик, тоон мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, гүйцэтгэлийн үр дүн, мэдээллийн үнэн зөв байдлын аудитыг хөгжүүлэх, төрийн байгууллагуудын харилцаа, мэдээлэл солилцоо, уялдаа холбоог сайжруулах, хэлбэрийн төдий дотоод хяналтын тогтолцоог өөрчлөх; | 11.1. Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын системийг төрийн албан хаагчийн цалингийн сантай уялдуулах ажлыг сайжруулах, үр дүнг тооцох | Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын системийг төрийн албан хаагчийн цалингийн сантай уялдуулах ажлыг сайжруулж, програмын хөгжүүлэлт хийгдсэн байх | Эхний хагас жилд, жилдээ | Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын системд бүртгэлтэй, хууль ёсны томилгоотой төрийн албан хаагчдын цалин олгогддог болсон байна. | ТСГ, ТЗУГ |
| 6 | Зөвлөмж 2.6. Төрийн худалдан авалт, ханган нийлүүлэлт, хөгжлийн албан ёсны тусламж, татаас, тэтгэмж, хөтөлбөр болон эрх, тусгай зөвшөөрөл, концесс олгох зэрэг үйл ажиллагаатай холбоотойгоор авлига, залилангийн гэмт хэрэг гарахад нөлөөлөхүйц хүчин зүйлсийг арилгах, аудит хийхдээ хөндлөнгийн болон дотоод хяналтын зохистой горимыг сонгон хэрэглэх; | 12.1. Төрийн худалдан авалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрх, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулж, и-монголиа системд байршуулан, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах боломжийг бүрдүүлэх | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байх | Жилдээ | Төрийн худалдан авалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрх, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулж, и-монголиа системд байршуулсан байна. | ТБТГ, ТБГ, СБГ, НБББГ, ХЭЗГ, ТЗУГ, СХЭУГ |
| | Зөвлөмж 2.7. Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулахаас бусад тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжээс эрхэлж буй аливаа үйлчилгээ, үйл ажиллагаанд хуульд заагаагүй зөвшөөрөл олгодог явдлыг таслан зогсоох, төр өөрт байгаа мэдээллээ иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг тогтолцоог халах; | 13.1. Тусгай зөвшөөрлийг и-монголиа системд байршуулан, иргэд аж ахуйн нэгжид чирэгдэл учруулахгүй байх | Төрийн байгууллагаас зохих мэдээллийг байршуулсан байх; | Жилдээ | Тусгай зөвшөөрлийн мэдээллийг и-монголиа системд байршуулсан байна. | ТБТГ, ТОХ ТЗУГ, СМТХ |
| 7 | Зөвлөмж 2.10. Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн иж бүрэн байдлын түвшинг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бүртгэлийг боловсронгуй болгох, кодлох, шилэн дансны нэгдсэн системийг нээлттэй өгөгдлийн зарчмаар шинэчлэх, аудитын явцад олон нийтийн зүгээс дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлсэн албан ёсны механизмыг бүрдүүлэх. | 15.1. Төсвийн хөрөнгө оруулалтаар болон, урсгал төсвөөр худалдан авах, бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, худалдан авах үйл ажиллагааны явц, худалдан авалт, гэрээ гүйцэтгэлийг шилэн дансанд тухай бүр нийтлэх | Тухайн жилийн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээ хуулийн дагуу хийгдсэн байх.<br>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байх. | жилдээ | Төсвийн тухай, Шилэн дансны тухай, худалдан авах үйл ажилаганы тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүртгэл хөтлөлтийн стандарт бүрэн хангасан байна. | ХСХОГ, ТЗУГ, СХ |
| | **2. Авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр** | | | | | |
| 2.1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг) мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх | Баримтжуулж, дүнг тооцож тайлагнасан байх /түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо/, харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх | Жилдээ | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг цахим хуудас, нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбарт байршуулж, иргэд, олон нийтэд сурталчилсан байна. | ТЗУГ, СХЭУГ |
| | | 1.2. Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулсан байх | Дэмжиж хамтран ажилласан байх /2-оос доошгүй өдөрлөг нөлөөллийн үйл ажиллагаа г.м/, үр дүнг тооцож нотломжийг хавсаргасан байх. | | Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг дэмжиж ажилласан байна. | ТБГ, ТССГ, ТЗУГ, СХЭУГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшил 110" мэдээллийн самбар ажиллуулах | Мэдээллийг сар бүр шинэчлэх, энэ тухай нотломжийг хавсаргасан байх. | | Мэдээллийн булан, самбар тогтмол ажиллуулсан байна. | ТЗУГ |
| | | 1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий /шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон/ сурталчилгааг хийж, олон нийтэд хүргэсэн байх | 2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, инстаграм ютуб суваг/ лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх, Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх | | Сурталчилгааны материал боловсруулсан, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбарт байршуулж олон нийтэд хүргэсэн байна. | ТЗУГ, бусад газрууд |
| 2.2 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | 2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах саналаа Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүлсэн байх | Сургалтад хамруулах захиалга өгсөн, сургалтад хамруулсан байх, тайланд нотломжийг хавсаргасан байх | Жилдээ | Саналыг хүргүүлсэн, тухайн албан хаагчдыгсургалтад хамруулсан байна. | ТЗУГ |
| | | 2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг /тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м/ байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэлх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах | Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх, тайланд нотломжийг хавсаргасан байх. | | Ажил үйлчилгээ гэрээлж гүйцэтгэх гэрээнд авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх асуудлаар тодорхой арга хэмжээ зохион байгуулсан байх талаар тусгасан байна. | Бүх газрууд |
| 2.3 | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшил хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах арга хэмжээ авсан байх | Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг гэрээнд тусгасан байх, хэрэгжилтийг үнэлж дүгнэсэн байх, тайланд нотломжийг хавсаргасан байх | Жилдээ | Ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээнд авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх асуудлыг тусгасан байна. Үр дүнг тооцсон байна. | НБББГ, ТБГ, ТЗУГ |
| | | 3.2.АТГ-аас ирүүлсэн Төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам хэрэгжүүлэх | Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх, сургалт мэдээлэл авсан байх, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх | Жилдээ | Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлсэн байх, тайлан зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлсэн байх | Бүх газрууд |
| | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/ | Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч үр дүнг тооцсон байх, тайланд нотломжийг хавсаргах | Жилдээ | Санхүүгийн салбарын төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үе шаттай, иргэд, олон нийтэд хүргэсэн байна. | Бүх газрууд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.4 | | 4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх | Хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан байх, үр дүнг тооцож арга хэмжээ авсан байх, тайланд нотломжийг хавсаргах | Жилдээ | Хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулсан, үр дүнг тооцсон байна. | Бүх газрууд |
| | | 4.3.Үйлчлүүлэгчээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурласан арга хэмжээ зохион байгуулах | Бодит үр дүнг тооцсон байх, тайланд нотломжийг хавсаргасан байх | Жилдээ | Сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурласан арга хэмжээ зохион байгуулсан байна. | ТЗУГ, СХЭУГ |
| 2.5 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачлага өрнүүлэх | 5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улирал, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдад танилцуулах | Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх, албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх, тайланд нотломжийг хавсаргасан байх | Жилдээ | 2023 оны төлөвлөгөөг 1-р улиралд багтаан баталсан байна. Хэрэгжилтийн явцыг 6-р сарын 25, хэрэгжилт үр дүнг 12-р сарын 25-ны дотор АТГ-т хүргүүлсэн байна. Танилцуулгыг хийсэн, санал санаачилгыг хэлэлцсэн байна. | Бүх газрууд |
| | | 5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал зөвлөмжийг тусгасан байдал | Саналыг тусгасан байх, тайланд нотломжийг хавсаргасан байх | | Дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал зөвлөмжийг тусгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Ирүүлсэн санал зөвлөмжтэй холбогдох газрууд |
| | | 5.3.Удирдлага салбар нэгж байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил арга хэмжээг төлөвлөн тайлагнах | Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангах, хэрэгжилтийг тайлагнасан байх | Жилдээ | Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнасан байна. | ТЗУГ |
| | | 5.4.Яамны нийт албан хаагчдаар 3Г-аас 2023 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласантай холбогдуулан 5Ш хөтөлбөрийг судлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах, үр дүнг тайлагнах | Засгийн газрын шийдвэрийн Сангийн яаманд холбогдох асуудлыг хэрэгжүүлэн ажилласан байх | Жилдээ | Сангийн яаманд холбогдох арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг тооцон ажилласан байна. | ТБТГ, СБГ, ТБГ, ХСХОГ, ТСГ, ХЭЗГ, ТЗУГ, СХЭУГ |
| | | 5.5.Яамны газар, хэлтсийн дарга нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачигын манлайллын асуудлыг нэмэлтээр тусгаж үр дүнг тооцох | Газар, хэлтсийн дарга нар 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлтээр авлигын эсрэг үйл ажиллагааг тусган хэрэгжүүлсэн байх | Жилдээ | Авлигын эсрэг асуудлаарх шинээр санаачилсан ажлын хүрээнд удирдлагын манлайллыг үнэлж дүгнэсэн байна. | Газрын удирдах албан тушаалтнууд |
| | | 5.6.Авлигын хор хөнөөлийг бууруулах талаар олон улсын түвшинд санхүү, төсвийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг судалж, албан хаагчдад сургалт мэдээлэл зохион байгуулах | Сургалт зохион байгуулагдсан байх | 2-р улиралд | Олон улсын сайн туршлагыг төсөв санхүүгийн салбарт нэвтрүүлэх санаачилга гаргасан байна. | СТСГ |

*Жич: Тайланг зураг, тоон үзүүлэлтээр баримтжуулан, дүгнэх хуудсанд хавсаргаж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар санал, хүсэлтээ тусган 2022 оны 06 дугаар сарын 20, 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.*